

Барилгын хөгжлийн төв
Барилга, байгууламжийн зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

Барилга, байгууламжийн зураг төслийн бүрдэл хэсгийн нэр /Дулаан хангамж:/

"Урандөш хүүхдийн цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн барилга"-ын ажлын зураг төсөл, төсөв

2024 оны 08 сарын 20 өдөр

Д/д	Утга	Тайлбар
1	Барилга байгууламжийн нэр	"Урандөш хүүхдийн цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн барилга"-ын ажлын зураг төсөл, төсөв
2	Барилга байгууламжийн байршил, хүчин чадал	Хөвсгөл аймаг, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон баг
3	Зураг төслийн байгууллага	"Пико инженеринг" ХХК
4	Зургийн шифр	ПИ.М-2022/12
5	Хуудасны тоо	ХАС-13. Гүйцэтгэсэн П.Отгонбаатар инженер П.Солонго.
6. Дүгнэлтийн товч утга: /Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоос/		
1	6.12.1. архитектур төлөвлөлтийн болон зургийн даалгавар, загвар зураг, эх загвар зураг/эскиз/, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүдийг тодорхойлсон, техникийн нөхцөлтэй эсэх;	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын халаалт агаар сэлгэлтийн системийн зургийг БА-ийн даалгаврыг үндэслэн БНБД23-01-09, БНБД25-01-20, БНБД41-01-11, БНБД31-03-03 ийг баримтлан гүйцэтгэсэн. Гадна агаарын тооцоот хэм -38,9 ⁰ С. Халаалтын системийн дулаан зөөгчийн хэм 70/60 ⁰ С. Халаалтын эх үүсвэр Дакон ПТЕ-60кВт-ийн цахилгаан тогоо. Дулааны ачаалал: Q=70кВт. Хэрэгцээний халуун ус цахилгаанаар.
2	6.12.2. холбогдох мэргэжлийн байгууллагаар энэ дүрмийн 5.2-т заасны дагуу хянуулж, дүгнэлт гаргуулж баталгаажуулсан эсэх;	ХАС-ийн зурганд зөвшилцсөн тэмдэглэл тамга байхгүй учир ОБГазар, ЭМГазрын дүгнэлтүүдийг ирүүлэх.
3	6.12.3. барилга байгууламжийн архитектур төлөвлөлт, барилга бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь норм, нормативын баримт бичиг, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, инженер геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцлийн дагуу боловсруулсан эсэх;	1. Барилгын дулааны эр үүсвэр нь цахилгаан тогоо байхаар төлөвлөсөн. Доороос түгээлттэй 2 хоолойтой хувиарлах коллектортой системтэй халаах хэрэгсэл нь доороос холболттой ган хавтгайлжин радиатор. 1-р давхрын ангий бүлгийн өрөөнд шалны халаалт төлөвлөсөн. 2. Анги бүлгийн өрөөнүүд, хоол бэлтгэх гал тогоо, угаалгын өрөөнд агаар сорох механик систем төлөвлөсөн. БНБД31-24-22-ийн холбогдох заалтыг мөрдөөгүй. 3. Барилгын эрчим хүчний гэрчилгээ хийгээгүй.
4	6.12.4. хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангуулсан эсэх;	БНБД12-03-04, БД12-101-05-ийг баримтлах талаар тайлбарт бичсэн.
5	6.12.5. барилгын ажлын талбай, үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагааны нөхцөл шаардлагыг тусгасан эсэх;	Ажлын зургийн шатанд барилгын ажлын талбай, үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөл хийгдэхгүй.
6	6.12.6. инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаарх дүгнэлттэй эсэх;	1. Гадна дулаан хийгдэхгүй цахилгаан тогооноос хангахаар төлөвлөсөн. 2. Цахилгаан тогооны ДМ-ийн зурагт өөрчлөлт оруулах шаардлагатай.
7	6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангуулсан эсэх;	ХАС-ийн хэсэгт хамааралгүй.
8	6.12.8. эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх;	Төсвийн хөрөнгөөр. Тасавт өртгийг объектийн нэгдсэн төсвөөс үзнэ.
9	6.12.9. зураг төслийн сонгосон шийдэл, магадлал хийх явцад экспертээс өгсөн нэмэлт, өөрчлөлтийн саналыг зураг төсөлд тусгасан эсэх.	1. ХАС-ийн системийн зургийн талаарх санал дүгнэлтийг Хавсралт №2-т үзнэ.
Дүгнэлт бичсэн Эксперт № 3-4 Г.Дамдинрагчаа 03-431		

2024 оны 08 сарын 20 өдөр

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЭЛ ХЭСГИЙН НЭР

"Урандөш хүүхдийн цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн барилга"-ын ажлын зураг төсөл, төсөв

2024 оны 08 сарын 20 өдөр

Д/д	Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил	Биелэлт
1	<p>1. Өргөтгөлийн барилга барих талаарх ямар шийдвэр байгаа вэ? Зургийн даалгавар, архитектур төлөвлөлтийн даалгавар, зураг төсөл хийх гэрээ, мөн халаалтын эх үүсвэрийг цахилгаан зуухаар хангах гэх мэт.</p> <p>2. Барилгын дулааны ачаалал Q=70кВт юм бол 60кВт-ын цахилгаан зуух 1-ийг сонгох боломжгүй ш дээ. Ер нь бол ямар ч зуух заавал нөөцтэй байх шаардлагатай. Иймээс 60кВт-ийн 2 ш эсвэл 60кВт-1, 45кВт 1-ийг тавих шаардлагатай.</p> <p>3. Цахилгаан тогооны байгуулалт, огтлолыг М1:50-иар зурах. /Бүх хэмжээсүүдийг харуулах.</p> <p>4. Тогооны өөрийнх нь насосны бүтээл, даралт халаалтын системийн шаардлагатай даралтыг хангаж чадах эсэхийг зөв тооцох.</p> <p>5. Шалны халаалтын гадаргуу даарх тем-рыг 22°C байлгах шаардлагатай гэж бичсэн байна. Энэ тохируулгыг яаж хийхээр тооцооноо тайлбарлах.</p> <p>6. 1-р давхар, 2-р давхрын дулаан алдагдлыг дахин шалгаж үз. Хучилтын дулаан алдагдал шалаар алдах дулаан алдагдал яг адилхан байгаа чинь эргэлзээтэй байна.</p>	<p>1.Төлөвлөж буй барилгын талаарх материалыг хавсаргаж оруулав. 2 Экспертийн саналыг хүлээн авч зурагт засвар оруулж 2 ширхэг Q-70кВт цахилгаан зуух байхаар төлөвлөв. 1 ширхэг нь нөөцөнд байхаар төлөвлөж гүйцэтгэв. 3. Экспертийн саналыг хүлээн авч зурагт тусгав. 4.Тооцоог шалгав 5. Шалны халаалтын тохируулгын схемийг зурагт тусгав. 6. Дулаан алдагдлын тооцоог дахин шалгаж засварлав</p>
2	<p>1. БНБД31-24-22-ийг үзэж халаалт агаар сэлгэлтийн системээ төлөвлөх.</p> <p>2. Дээрх нормын 7.2-ийн бүх заалт, Хавсралт-Е-г судлаж ХАС-ийн системийг төлөвлөх.</p> <p>3. Анги бүлгийн өрөөнүүдэд тухайн орон нутгийн гадна агаарын температур, агаарын чанараас хамаарч гаднаас агаар оруулах систем төлөвлөөгүй тохиолдолд агаар сорох механик ажиллагатай систем төлөвлөх боломжгүй.</p> <p>4. MNS3240:2013 болон Этолон зургийн дагуу халаалтын байгуулалтын өрөөний тодорхойлолтонд дотор агаарын хэм болон дулаан алдагдал кВт-аар, агаар сэлгэлтийн байгуулалтанд өрөөний оруулах болон зайлуулах агаарын хэмжээ м3/ц аар бичигдэх ёстой.</p> <p>5. ХАС-ийн зургийг инженерийн бусад хэсгүүдтэй заавал зөвшилцөх, ялангуяа цахилгааны инженер энэ барилгын цахилгааныг хангахаар төлөвлөсөн эсэх.</p> <p>6. БХБ-ын болон ЭХ-ий сайдын 2021-оны А/257, А/252-р тушаалын хавсралт, мөн БНБД25-01-20, БНБД31-24-22-ийн 8-д заасны дагуу "БАРИЛГЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ГЭРЧИЛГЭЭ"-г хийж хавсаргах.</p>	<p>1 Бнбд 31-24-22 дагуу ХАС-г төлөвлөж шаардлагатай өөрчлөлтүүдийг хийж гүйцэтгэв. 2.Засаж гүйцэтгэв. 4 Дээрх нормын дагуу 1хүүхдэд 20м3/ц агаар байхаар тооцоож агаар сэлгэлтийн механик систем төлөвлөв. Мөн G4+F5+F7 3 давхар шүүлтүүр байхаар тусгав Бнбд 31-24-22 дагуу ХАС-г төлөвлөж шаардлагатай өөрчлөлтүүдийг хийж гүйцэтгэв. 5 Хорших хэсгүүдтэй зөвшилцөж баталгаажуулав 6. Эрчим хүчний гэрчилгээ хавсаргаж гүйцэтгэв.</p>
3	<p>1. ОБГазар, ЭМГазруудтай зөвшилцсөн дүгнэлтүүдийг магадлалд ирүүлэх. Энэ дүгнэлтийн биелэлтийг бичихдээ дүгнэлтүүдийн заалтад ХАС-ийн системийн талаар ямар нэгэн заалт байгаа эсэхийг үзэж огноо, дугаарыг тодорхой бичих.</p>	<p>Онцгой байдлын дүгнэлт, Эрүүл мэндийн дүгнэлтүүдийг хавсаргаж оруулав.</p>
<p>Дүгнэлт бичиж, биелэлтийг шалгасан эксперт № 3-4</p>		<p align="right">..... /Г.Дамдинрагчаа/ оны сарын өдөр</p>
<p>Биелэлтийн тайлбар бичсэн</p>		<p align="right">..... /П.Отгонбаатар/ оны сарын өдөр</p>
<p>Дүгнэлт бичиж, биелэлтийг шалгасан эксперт № 3-4</p>		<p align="right">..... /П.Отгонбаатар/ 2024 оны 09 сарын 03 өдөр</p>